

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Багшийн мэргэжлийг дээшлүүлэх институт” /цаашид “Институт” гэх/ нь үндэсний болон орон нутгийн түвшинд багш, удирдах болон бусад мэргэжлийн ажилтан (нийгмийн ажилтан, эмч, тогооч гэх мэт), Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн ерөнхий боловсролын багшийн мэргэжлийг боловсролын хөгжлийн бодлого болон тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан байнга, тасралтгүй дээшлүүлэх мэргэжлийн үйлчилгээг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, төвлөрсөн болон мэдээлэл, холбооны технологид суурилсан мэргэжил дээшлүүлэх байнгын сургалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий сургалт, арга зүй, судалгааны байгууллага мөн.

1.2 Институт нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сайдын тушаал, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр болон энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

1.3. Институт нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.4. Институт нь өдөр тутмын үйл ажиллагаагаа институтын удирдах байгууллагын шийдвэр, институтын захирлын тушаал болон хөдөлмөрийн дотоод журмын дагуу явуулна.

Хоёр. Институтын үйл ажиллагааны зарчим, үндсэн чиглэл

2.1 Институт нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлана:

2.1.1. Боловсролын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэх;

2.1.2. Багшийн хөгжлийн талаархи олон улсын жишиг, чиг хандлагыг баримжаалах;

2.1.3. Багш бүрийг мэргэжил, арга зүйн ур чадвараа дээшлүүлэх адил тэгш боломжоор хангах;

2.1.4. Багшийн мэргэшил дээшлүүлэх сонголттой, нээлттэй, уян хатан, тасралтгүй үйлчилгээг бий болгох;

2.1.5. Мэргэжил дээшлүүлэх сургалтад мэргэжлийн байгууллагын оролцоог хангах;

2.2 Институт нь өөрийн чиг үүргийн хүрээнд дор дурьдсан үйл ажиллагааг явуулна.

2.2.1. Багшийн мэргэжил дээшлүүлэх нөхцөл байдал, хөгжлийн хандлага, эрэлт, нийлүүлэлтийн уялдаа, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ хийх;

2.2.2. Мэргэжил дээшлүүлэх ажлын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийг олон улсын хөгжлийн жишиг хандлага, өөрийн орны онцлог, багшийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн боловсруулж, Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулж ажиллах;

2.2.3. Үндэсний болон орон нутаг, нэгж байгууллагын түвшинд багш, удирдах ажилтны мэргэжлийг дээшлүүлэх нэгдсэн зохицуулалтыг хангах;

2.2.4. Багшийн мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр орон нутгийн боловсролын удирдлага, нэгж байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, орон нутгийн түвшинд багш нарын мэргэжлийг ерөнхий боловсролын лаборатори сургуулиудад түшиглэн дээшлүүлэх;

2.2.5. Багшийн мэргэжлийг зайны сургалтаар дээшлүүлэх мэдээлэл, холбооны технологид суурилсан үндэсний сүлжээг бий болгох,

2.2.6. Интернетэд суурилсан сургалтын нээлттэй хэрэглэгдэхүүний үйлчилгээг бий болгох:

2.2.7. Багш бүрийн мэргэжлийг 5 жил тутамд дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах,

2.2.8. Боловсролын байгууллагын ажилтан, сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтанд мэргэжил дээшлүүлэх төвлөрсөн болон орон нутгийн сургалтыг зохион байгуулах;

2.2.9. Багш нарын мэргэжил дээшлүүлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх;

2.2.10. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хэрэглэгдэх ном, гарын авлага, зөвлөмж, электрон материалыг бэлтгэх;

2.2.11. Багш, удирдах ажилтны мэргэжлийг дээшлүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, мэргэжил дээшлүүлэх сургалтын чанар, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх;

2.2.12. Багшийн мэргэжлийг дээшлүүлэх асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах;

2.2.13. ЕБС, цэцэрлэгийн багш нарын мэргэжил ур чадвар дээшлүүлэх талаар гаргаж буй бүтээлч санаачлагыг дэмжих, багш нарын тэргүүний арга барил, туршлагыг судлан нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

2.2.14. Багш бэлтгэх, давтан бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

2.2.15. Багш, удирдах ажилтны мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөрүүдэд үнэлгээ дүгнэлт өгөх, үр дүнгийн мэдээ тайланг авах;

2.2.16. Гадаад орны ижил төрлийн байгууллагуудтай багш, удирдах ажилтны мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах, багш, удирдах ажилтныг гадаад оронд явуулж мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

2.2.17. Багшлах эрх болон мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах;

2.2.18. Оны шилдэг багш шалгаруулах, багшийн ур чадварын уралдаан зохион байгуулах;

Гурав. Институтын удирдлага, зохион байгуулалтын бүтэц

3.1. Институтын удирдлага нь удирдах зөвлөл, захирал, захирлын зөвлөл, орон тооны бус мэргэжлийн зөвлөл, нэгжийн дарга нараас бүрдэнэ.

3.2. Институтын бүтэц, орон тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.3. Институтын ажилтнуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг байгууллагын дотоод журмаар зохицуулна.

3.4 Удирдах зөвлөл

3.4.1. Удирдах зөвлөл нь институтын сургалт, арга зүй, судалгааны ажлын үндсэн чиглэлийг тодорхойлох, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг хэлэлцэж батлах, түүний гүйцэтгэлийг хянах, үр дүнг үнэлэх эрх бүхий хамтын удирдлагын байгууллага мөн.

3.4.2. Удирдах зөвлөлийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан дарга ахлах бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг сайд батална.

3.4.3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана.

3.5. Захирал

3.5.1. Институтыг захирал удирдах бөгөөд түүнийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

3.5.2. Захирал нь сургалт, хүний нөөц, захиргаа, санхүү, төсвийн зарцуулалт зэрэг асуудлаар институтыг шуурхай удирдлагаар ханган ажиллаж, удирдах зөвлөл болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлаа тайлагнана.

3.5.3. Захирал нь институтын болон түүний нэгжүүдийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнг үнэлж дүгнэх, нэгжүүдийн ажлын уялдаа холбоог хангах, баталсан төсвийн хүрээнд хөрөнгө захиран зарцуулах, дэд захирал болон нэгжийн удирдлага, бусад албан тушаалтан, ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдэлнэ.

3.5.4. Захирал өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.

3.5.5. Захирал нь зохих хууль тогтоомжийн дагуу боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй үр дүнгийн гэрээ байгуулж түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.6. Захирлын зөвлөл

3.6.1. Захирлын зөвлөл нь институтын захирал, дэд захирал, сургалтын албаны дарга, тэнхмийн эрхлэгч нараас бүрдэх бөгөөд захиралд зөвлөх чиг үүрэг гүйцэтгэнэ.

3.6.2. Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг институтын захирлын тушаалаар батлана.

3.7. Орон тооны бус мэргэжлийн зөвлөл

3.7.1. Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг сургалтын чиглэл бүрийн тэргүүлэх мэргэжилтнүүдээс бүрдүүлж, институтын захирлын тушаалаар батална.

3.7.2. Орон тооны бус мэргэжлийн зөвлөл нь багшийн мэргэжил дээшлүүлэх батлагдсан төлөвлөгөөний дагуу боловсруулсан сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтад хэрэглэгдэх ном, гарын авлага, зөвлөмж, электрон материалыг хэлэлцэж, дүгнэлт гаргана.

3.7.3. Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажлын хөлсийг институтын төсөвт багтаан шийдвэрлэнэ.

3.8. Нэгжийн удирдлага

3.8.1. Институтын нэгжийн удирдлагууд нь хариуцсан нэгжийн үйл ажиллагааг тасралтгүй шуурхай удирдлагаар хангах, нэгжийн зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааны төлөвлөгөөг биелүүлэх үүргийг захирлын өмнө хүлээнэ.

3.8.2. Институтын дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр нэгжийн удирдлага, бусад ажилтнуудын эрх үүрэг хариуцлагыг нарийвчлан тодорхойлно.

Дөрөв. Институтын санхүүжилт

4.1. Институтын үйл ажиллагаа дараах эх үүсвэрээс санхүүжинэ. Үүнд:

4.1.1. Улсын төсвийн хөрөнгө

4.1.2. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

4.1.3. Эрдэм шинжилгээ, судалгааны төслийн санхүүжилт

4.1.4. Хууль тогтоомжоор хориглоогүй санхүүгийн бусад эх үүсвэр

Тав. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

5.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

..... о О о